

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 089-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-32

- 1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/** 5-31
- 2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/** 31-32

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 09-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 18 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Номин;
Чөлөөтэй: Ч.Анар;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар;
Тасалсан: С.Цэнгүүн.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Соноор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Ганзориг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, мөн яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баясгалан, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Бат-Өлзий, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга П.Дэлгэрмаа, мөн хэлтсийн шинжээч Д.Мөнхсолонго, Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтсийн дарга Ч.Гүнсэнхорол, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Эрдэнэ, И-Монгол академи Улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Б.Мягмарнаран, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирал С.Жавхлан, Радио телевизийн үндэсний сүлжээ Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Ж.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Ж.Галбадрах, Ч.Ундрэм, Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Ганзориг, И-Монгол академи Улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Б.Мягмарнаран, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирал С.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ж.Золжаргал: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм гаргасан, “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын урсгал зардлын ангилалд байгаа Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 1,5 тэрбум төгрөгийн төсвийг боловсролын салбарын багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд шилжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 4
Бүгд: 8
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Золжаргал: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 4
Бүгд: 8
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 3
Бүгд: 8
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Золжаргал: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 3
Бүгд: 8
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

Нэг.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 46 минут үргэлжилж, 12 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Даваа гараг
Төрийн ордон “Их засаг” танхим, 13 цаг 18 минут

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Гишүүдийн ирц 58,3 хувиар бүрдсэн байна. Мөнхбат гишүүн ирсэн байна. Батшугар гишүүн ирсэн байна. Чинбүрэн гишүүн байгаа. Пунсалмаа гишүүн ирсэн байна. Ундрам гишүүн ирсэн байгаа. Галбадрах гишүүн, Золжаргал гэсэн ийм ирцтэй байна. Ирцээ бөглөөрэй.

Ингээд хэлэлцэх асуудлыг гишүүддээ танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

2 дугаарт нь 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд гэсэн ийм 2 асуудал байна. Хэлэлцэх асуудал дээр нэмэлт саналтай гишүүд байна уу. Хэлэлцэх асуудалдаа орёе.

Ингээд 1 дүгээрт нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг эхлүүлье.

Хэлэлцэх асуудалтай холбоотой ажлын хэсгийнхнийг оруулна уу. Ажлын хэсгийн хүн нь ирсэн үү. Сангийн сайд Жавхлан байгаа юм уу, байхгүй. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Баатархүү сайд байгаа юм уу. Байнгын хорооны хурал дээр байна. Байнгын хорооны хурал дээр байна. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Алтан-Од, Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхтуяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Эдийн засаг хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох байхгүй байгаа юм байна. Эдийн засаг хөгжлийн яамны Технологи инновац, шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга

Урьболд, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Отгонцэцэг Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Баясгалан, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Бат-Өлзий, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Дэлгэрмаа, Шуудан өргөн нэвтрүүлгийн хэлтсийн дарга Гүнсэнхорол, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Эрдэнэ, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч Мөнхсолонго, И-Монгол академи Улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Мягмарнаран, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга Батбаатар, Үндэсний дата төв УТҮГ-ын захирал Баттулга, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Золбаяр, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирал Жавхлан, Радио телевизийн Үндэсний сүлжээ УТҮГ-ын захирал Энхбат гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Манай Байнгын хорооны ажлын албаныхан ирэх хүмүүсийнхээ нэрийг урьдчилж аваад, энэ дээр ирсэн, ирээгүйгээр нь дараа нь тэмдэглэж байгаарай. Шаардлагагүй бол бүгдийг нь уншихаар бас ирээгүй хүмүүс төвөгтэй юм.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг сонсоно. Сангийн сайд Жавхлан танилцуулга хийх үү. Орлож байгаа хүн танилцуулга хийх юм уу. Засгийн газрын гишүүн Баатархүү сайд болж байна. Орж ирж байна гэсэн үү. Тэгвэл хүлээе тэгэх үү. Ирц бүрдчихсэн. Тэгвэл Сангийн сайдыг ирэх хооронд аудитынхаа дүгнэлтийг сонсчихъё. Сангийн сайд Жавхлан таны танилцуулгыг сонсьё.

Б.Жавхлан: Баярлалаа. Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан. Үүний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлага бий болж байна гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл гарч, Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулан ийнхүү танилцуулаад явж байна.

Төсвийн төсөл зардлыг бууруулахад дараах зарчмыг баримталлаа.

1.Нийгмийн даатгалын сангаас олох тэтгэвэр, тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, Нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан

хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад 1 удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж зэрэг өрхийн орлогод шууд нөлөөлдөг эдгээр төсвийн зардлуудыг хэвээр нь үлдээлээ.

Мөн гадаад зээлийн үйлчилгээний төлбөр мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос төсвийг нь хянаж, жилийн төсөвт тусгуулахаар ирүүлдэг байгууллагууд болон ХЭҮК зэрэг байгууллагын урсгал зардлыг хэвээр нь үлдээлээ.

2.Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-100 хувь бууруулна.

1 дүгээрт салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан, тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь буурууллаа.

2.Соёлын эрхийн бичиг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино үйлдвэрлэлийг дэмжих сан, Засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдрал хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулна.

3.Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр, шатахууны зардал, төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин, төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх шатын төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлыг тус бүр 50 хувиар буурууллаа.

Дээр дурдсан 50-100 хувь бууруулах зардлуудаас гадна, байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативд эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийн хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан боловч төсөл арга хэмжээнээс гэрээ байгуулсан ажлыг эхлүүлсэн төслүүдийг нь бол дуусгахаар хойтон үргэлжлүүлнэ. Харин гэрээ байгуулаагүй, ажил эхлээ эхлээгүй, 12 сарын 2-ны байдлаар шүү эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эрэмбэлж хойшлуулна. Зарим их засвар, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа төслийг хойшлуулна.

Гадаад зээлийн ашиглалтыг тодорхой хэмжээнд бууруулахаас аргагүй болж байна. Хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийн ашиглалтыг мөн хойшлуулъя.

Хавдар судлалын үндэсний төв 2 хөрөнгө оруулалтыг нэмж тусгалаа. Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394,8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн дүн 33,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий бүтээгдэхүүний 35, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 33,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувьд хүрч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцэл ДНБ-ий 3,3 хувиа эерэг болгохоор тооцлоо.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсан баярлалаа.

Ж.Золжаргал: Жавхлан сайдад баярлалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Самбууням дарга танилцуулна.

Я.Самбууням: Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн тайлан, дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй байх шаардлагатай гэсэн үндэслэлээр бүхэлд нь хориг тавьсан байна.

Улсын Их Хурлын чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүл хүлээн авч алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж өргөн барьсан байна.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод нийцсэн эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 33 их наяд 470 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35,2 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 3 их наяд 173,4 тэрбум

төгрөгийн ашигтай буюу ДНБ-ий 3,3 хувь, тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байхаар тус тус төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдлаар төлөвлөжээ. Үүнд:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын төвлөрүүлэх орлогыг 8,7 тэрбум, зарлагыг 118,5 буюу суурь түвшнээс 10,6 тэрбумаар бууруул, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төвлөрүүлэх орлогыг 2,4 тэрбум, зарлагыг 276,1 тэрбум буюу суурь түвшнээс 36,2 тэрбум төгрөгөөр бууруулан тус тус баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал улс улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг цаашид анхаарах нь зүйтэй гэж дүгнэлээ.

1 дүгээрт гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай байна.

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөвт өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.

3.Цахим систем, ТЭЗҮ боловсруулах, ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлтэй тооцож үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4.Төсвийн урсгал зарлагыг хумьж зарим хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын ДНБ-д эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг хумих эрсдэл үүсэх магадлалтай байна.

5.Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэц, ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль, эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиуд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагад нийцэж байна гэж дүгнэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Тэгээд хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд, гишүүдэд цаасаар хүргүүлсэн байгаа.

Одоо хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү. Асуух асуулт 6 гишүүн нэрээ өгсөн байна. Ингээд ирцийн дагуу Батшугар гишүүн асуултаа асууна уу.

Э.Батшугар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Баатархүү сайдаас хэд хэдэн асуулт асууя.

1 дүгээрт Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд маш чухал заалт орчихсон байгаа юм. Энэ нь төр өөрт байгаа мэдээллийг иргэнээс, аж ахуйн нэгжээс асуухгүй, шаардахгүй гээд. Үүнтэй холбоотойгоор энэ оны нэг сард Улсын Их Хурлаас 1 тогтоол баталсан. Энэ тогтоолдоо ч гэсэн бас үүнийг оруулсан байгаа юм. Нэг ёсны иргэнээс төр өөрт байгаа мэдээллээ асуухгүй гэж байгаа юм. Яг практик дээр ямар шаардлага тавигдаж байгаа вэ. Үүнтэй холбоотойгоор гэхэд жишээлбэл нэг иргэн тэтгэвэрт гарах гэж байна. Тэгэхээр нөгөө иргэнийг чинь маш олон төрийн байгууллагууд руу явуулаад байдаг. БЗД-ийн нийгмийн халамжийн газраас тийм бичиг аваад ир, тэрнээс тийм бичиг аваад ир гэх мэтчилэн. Энэ чинь өөрөө хүнд суртал авчраад байгаа юм. Тэгсэн мөртөө хуульдаа заачихсан байгаа. Мөн тогтоолд оруулчихсан байгаа юм. Хур систем, Дан системээр дамжуулаад төр өөрт байгаа мэдээллийг бусад агентлаг, Засгийн газрын яамдаас татаж аваад иргэндээ шууд үйлчлэхээр, аль ч аж ахуйн нэгж ч гэсэн мөн адилхан. Үүний хэрэгжилт нь аль түвшинд явж байгааг асууя.

2-т нь бол сая 1 сард батлагдсан тогтоол дээр нэг чухал заалт орсон байгаа нь бол энэ “хурдан” төвүүдийг сум болгонд, хороо болгонд байгуулна гээд. Энэ нэг ёсны Монгол улсын иргэн төрийн үйлчилгээ авах гэж байгаа бол заавал нэг цэгийн үйлчилгээний газар жишээлбэл Дүнжингарав эд нар дээр очихгүйгээр хамгийн өөрт байгаа ойрхон хорооны байран дээр очоод “хурдан” цэгийн нийт үйлчилгээ авах бололцоо нээгдэнэ. Аль эсвэл хамгийн ойрхон сумын төв рүүгээ очно. Заавал аймгийн төв рүү очихгүйгээр. Тэгэхээр үүний хэрэгжилт нь аль түвшинд явж байгаа вэ.

3-д нь сая энэ онд 109 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ бол цахимжилтыг Монгол Улсад дэмжсэн, дээрээс нь нэмээд хүнд суртал арилгахаар. Энийг яагаад би онцолж хэлмээр байна гэвэл өнөөдөр И-Монголиа ашиглалтад ороод, үүний үр дүнд бол 1,2 их наядын эдийн засгийн хэмнэлт гарсан. Яг үүнтэй адилхан бизнес эрхлэгч нарт зориулсан и-бизнес платформ гэж байгаа. Энэ нь И-Монголиагаас юугаар ялгаатай вэ гэхээр И-Монголиа иргэнд зориулсан платформ И-бизнес бол ААН-д зориулсан платформ. Тэгэхээр энэ бүх харилцааг нь бол цахимжуулж өгсөн. Үүний хэрэгжилт нь ямар байна. Нэг ёсондоо Монгол Улсын иргэн хэрвээ аж ахуйн нэгж байгуулмаар байгаа бол нэрээ урьдчилсан бүртгэлээс цахимаар авчихна. Банкаа цахимаар дансаа нээчихнэ. Дээрээс нь нэмээд компанийнхаа дүрмийн сан болон дүрмээ цахимаар батлаад, улсын бүртгэл явуулчихна. Тамгаа хүртэл цахимаар хийх эрх зүйн байдлыг нь нээж өгсөн байгаа. Тэгээд шууд компани нээх бололцоог нь хийчхэж байгаа юм. Тэгэхээр и-бизнесийн хэрэгжилт хэр зэрэг явж байна. Ер нь аж ахуйн нэгжүүдэд нэлээн тийм И-Монголиатай адилхан тийм хэмнэлт болж чадаж байна уу гэж асууя.

Бас дотоод роуминг гэж ярьдаг. Энэ Монголд хэрэгжих үү. Яагаад гэвэл ялангуяа хөдөө орон нутагт бол маш олон үүрэн холбооны оператор компаниуд тус тусдаа антен бариад байдаг. Тусдаа хөрөнгө оруулалт хийгээд байдаг. Тэгсэн мөртөө хоорондоо роуминг хийж чадахгүй domestik роуминг гэж ярьдаг даа.

Тэгэхээр энэ нь уг нь хэрэгжих л ёстой л гэж бодоод байгаа юм. Яг тайлбарлавал одоо жишээлбэл Жи мобайлын 1 антен нь шууд Юнител, Мобикомтойгоо 1 антенаа шэйрлээд роуминг хийх бололцоог нь хийчхэж байгаа юм. Тэгэхээр заавал Мобиком, Юнител, яг тэр баг дээр ч юм уу заавал антен байршуулахгүйгээр нэг нь байршуулчихвал хөрөнгө оруулалтаа хийчихвэл бусад нь тэрүүгээр нь дамжуулж шэйринг болон роуминг хийх бололцоог нь .../минут дуусав/

Ж.Золжаргал: Батшугар гишүүнд 1 минут нэмж өгнө үү.

Э.Батшугар: Энэ national roaming, domestic roaming гэж янз янзаар л ярьдаг л даа. Үүний Монголд хэрэгжих үү, дүрэм журам нь аль шатандаа явж байгаа вэ гэж асууя. Яагаад гэвэл энэ бол давхар зардал гаргахгүйгээр хэрэглэгч нар болон ард иргэддээ л илүү хялбар мэдээлэл технологийн сүлжээг л нээж өгч байгаа тийм том зүйл юм. Дэлхийн банкнаас цахим засаглал 2.0 хөтөлбөр явагдаж байгаа. Энэ нь гэрээгээ байгуулчихсан гэж ойлгож байгаа. Тэгээд хэрэгжилт нь аль түвшинд явж байгаа вэ. Хэдэн жилийн хөтөлбөр вэ. Яг үүнтэй холбоотойгоор цахим эрүүл мэндийн төсөл нэг ёсны хэрэгжиж чадаагүй. Фэйлдсэн гэж хэлж болно. Тэгэхээр энэ асуудал аль түвшинд байгаа вэ. Дэлхий банк миний сонссоноор Засгийн газраас эргүүлж хөрөнгө оруулалтаа төлүүлье гэсэн тийм бас бичиг явуулсан гэж сонссон. Тэгэхээр энэ талаар та бас дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч. Цахим эрүүл мэндийн төслийн талаар баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Энэ 2025 төсвийн жилд хийгдэх гол ажлуудыг дурдаж асуух шиг боллоо. 6 асуулт асуучихлаа шүү дээ. Тэгээд та бүхэн тус бүр дээр нь тодорхой хариулт өгнө үү. 4 номерын микрофон нээж өгнө үү. Баатархүү сайд.

Ц.Баатархүү: Байнгын хорооны дарга болон Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Батшугар гишүүн бол Монгол Улсыг дижитал шилжилт хийхэд хамгийн чухал суурь зүйлүүдийг хэлчихлээ. Ер нь бол одоо бол төрийн байгууллагууд цаасан дээр байгаа мэдээллээ бүгдийг нь дижитал болгосон. Хоорондоо солилцох асуудал бол удаашралтай байна. Энэ асуудлаар манай яам хамгийн түрүүнд ажлын хэсэг гараад, бүх мэдээлэл хариуцагч байгууллага буюу хурыг ашигладаг гол байгууллагуудын нэг УБЕГ, НДЕГ гэх мэт байгууллагуудтай бид нар уулзаж, ажлын хэсэг бол гаргасан. Бүхий л улс төрчид, сайд нар төрд байгаа мэдээллийг төрийн байгууллага нь нэхэхгүй гэж хэлдэг. Иргэд, хэвлэл мэдээлэлд ч гэсэн үүнд эргэлзээтэй байдлаар асуудаг болсон. Үүний учир шалтгаан юу байна вэ гэхээр хэд хэдэн бас процессын журамд өөрчлөлт оруулах шаардлага байна гэж бид нар үзсэн. Тэр дундаа шүүхийн шинжтэй байгууллага, хууль хяналтын байгууллагууд бол тодорхой журмуудаа шинэчилж бай, цаасан биш цахимаар энэ лавлагаануудыг авна гэдэг ийм зөвшөөрлийг өгөх юм байна. Тэгэхээр сая баталсан, өнгөрсөн онд баталсан 109 хууль дээр нэмээд тэр хуулийг дагах журмуудыг бид нар бол өөрчлөх шаардлага байгаа. Энэ нь бол зөвхөн манай яамнаас гадна мэдээлэл хариуцагч бүх байгууллагууд энэ журмаа яаралтай өөрчлөх, Засгийн газрын хурлаар батлуулж байж төрийн байгууллага хоорондоо бол мэдээллийг ил тод солилцох, иргэн ирээд төрд байгаа мэдээллийг нөгөө төрийн байгууллага нь дахин нэхэхгүй болох боломж бол бүрдэх юм байна лээ. Энийг бол 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газраар оруулахаар ажлын хэсэг бол ажиллаж байгаа. Энэ бол маш зөв зүйтэй санал. Та бас Улсын Их Хуралд бид нар ингэж дэмжиж ажиллаж байгаад бол баярласнаа илэрхийлье.

2 дугаарт нь бол И-Монгол дээр бол И-бизнес цонх байгаа. Засгийн газар дээр бид нар яриад зарим нэгэн төрийн чиг үүргийг Төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг болъё гэсэн ийм санаачилга гаргасан. Үндэсний ХАҮТ-тай хамтраад ер нь энэ бизнесийн үйл ажиллагааг цахимжуулах, хөнгөвчлөх энэ ажил дээр бол мэргэжлийн холбоод нь илүү санаачилгатай байя. Тийм учраас И-Монгол одоо бүгдийг нь хийх биш, И-Монгол бол платформ буюу технологийн шийдлийг нь гаргаад өглөө. Илүү оновчтой болгох энэ ажлаа Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим цаашдаа бол авч явахаар болсон байгаа. Энэ ажил яагаад нэг сар хойшилсон бэ гэхээр ХАҮТ-ын сонгууль болоод ингээд тодорхой хугацаагаар хойшилсон гэдгийг та бүхэн маань ойлгож байгаа байх. Ер нь төрд байгаа зарим нэгэн лавлагаа мэдээллийг зарим хувийн хэвшил зөвшөөрөхгүй байгаа хэвээрээ байгаа. Тэр дундаа банк санхүүгийн байгууллагууд одоо болтол И-Монгол дээр байгаа иргэний бүртгэлийн иргэний үнэмлэхийн тэр лавлагааг хүлээн зөвшөөрөхгүй, заавал цаасаар авчир гэдэг. Олон удаа бид нар банкны холбоо, банк санхүүгийн байгууллагатай уулзахаар бол одоо бид бол хүлээн зөвшөөрнө гэж хэлдэг. Гэхдээ яг ингээд салбарууд дээр очихоор ... /минут дуусав/

Ж.Золжаргал: Баатархүү сайд нэмэлт хугацаа өгье. 4 номер.

Ц.Баатархүү: Иргэдэд бол чирэгдэл учруулсан хэвээрээ байгаа. Банк бүр бид нар бол судалгаа авсан. Бүх салбаруудаар яваад яг ямар банкны аль салбар дээр цаасан лавлагаа нэхэж байна. Аль хэсэг дээр И-Монголыг зөвшөөрч байна гэдэг судалгааг бол бид нар хийсэн байгаа. Үүний араас бас дэлгэрэнгүй хариултыг манай И-Монголынхон өгнө гэдгийг хэлье.

Орон нутгийн Улсын Их Хурлын гишүүдээс хамгийн их хүсэж байгаа, тэгээд нөгөө талдаа манай энэ компаниудын хүсэж байгаа зүйлийг та бас илэрхийллээ. Энэ бол national routing. Ер нь бол сүүлийн жилүүдэд улсын төсвийн хөрөнгөөр хөдөлгөөнт холбоо буюу бидний хэлдгээр бол багуудад сүлжээ оруулах энэ ажил дээр компаниуд орохоо больсон. Учир юу юм бэ гэхээр нэгэнт цөөхөн айл байдаг учраас эдийн засгийн хувьд бол ашиггүй юм байна. Ашиглалт үйлчилгээг нь хэн хариуцах юм бэ гэдэг байдлаар бол өнгөрсөн жилийн бид нарын 100 цэгийн үйл ажиллагаа бол хангалттай болж чадаагүй. Тийм учраас энэ жилээс эхлүүлээд бид нар 2025 оноос бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг энэ national routing .../минут дуусав/

Ж.Золжаргал: 4 номер дээр микрофон нээж өгнө үү. Энэ уг нь хариулт өгөхдөө 4 минут, нэмэлт хугацаа 2 удаа тус бүр 1 минут гэсэн байгаа. Тэгэхдээ түрүүн 4 минутаас богино явчих шиг болох юм.

Ц.Баатархүү: Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаар энийгээ хийх нь зөв юм байна. Тэртээ тэргүй харилцаа холбооны компаниудын ашгийн 3 хувиар аялал жуулчлал, боомтууд, хүн хамгийн их төвлөрөх магадлалтай стратегийн бүс нутгуудад хөдөлгөөнт холбоог бид нар бол зайлшгүй тавих бол шаардлагатай. Улсын Их Хурлын гишүүдийн ирсэн бичиг, тэр орон нутагт амьдарч байгаа хүмүүсийн иргэдийн санал бодол, тэгээд аялал жуулчлал, эдийн засгийн чөлөөт бүс, боомтын хөгжил дэвшил зэрэг олон индикатор үзүүлэлтээр бол бид нар ирэх жилүүдэд 160 орчим цэгийг бол хөдөлгөөнт холбоонд national routing-ийн хүрээнд хамтарч бид нар хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа. Гол .../минут дуусав/

Ж.Золжаргал: Батшугар гишүүн тодотгоод асуучих уу. Нөгөө Дэлхийн банк цахим эрүүл мэнд энэ тэр гээд байна шүү дээ.

Э.Батшугар: Баярлалаа. Ялангуяа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт дээр Засгийн газар анхаарч ажиллаж байгаа юм байна. Холбогдох журмууд ч гэсэн бас батлагдах ёстой гэдгийг нь бол Засгийн газрын 1 дүгээр улиралд, ирэх онд оруулна гэж хэллээ. Энэ бас яалт ч үгүй аж ахуйн нэгжүүд болон иргэдэд маш их хэмжээний цаг хэмнэлт, хүнд суртлын арилгана.

“Хурдан” цэгийн талаар бас тодотгож асууя. Нөгөө аймаг, сум болгонд хороо болгонд “Хурдан” цэгийг байгуулж, төрийн үйлчилгээг ард иргэдээ ойртуулна. Мөн үүнтэй холбоотой “20 минутын хот”-ын концепт ч гэсэн нийцэж байгаа юм. Гол нь нөгөө Дэлхийн банкны цахим эрүүл мэнд төслийн талаар бас дэлгэрэнгүй асууя. Энэ юу болчхов. Нэлээн л хүлээлт өндөр байсан. Харамсалтай нь бол явж чадаагүй. Энэ 2-ыг асууя. Баярлалаа.

Ж.Золжаргал: Сайд уу. 4 номер.

Ц.Баатархүү: Яах вэ, зүгээр энд бага зэргийн мэдээллийн өөр ойлголт явж байна. Яг ухаалаг засаг 2-той бол энэ Дэлхийн банкны цахим эрүүл мэнд төсөл бол хамаарахгүй байгаа. Ухаалаг засаг 2.0 хөтөлбөр бол дөнгөж хэрэгжиж байгаа. Тэдний удирдах хороо ухаалаг засаг хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын энэ салбар, энэ яам дээр бол ийм цахим шилжилтийг хийх шаардлагатай гэдгийг удирдах хороо нь хуралдаад, иймэрхүү төсөв байх юм байна гэдгээ бүр удирдах хороо гаргачхаж байгаа юм. Тэгээд ажил бол эхлээд явж байгаа. Хамгийн түрүүнд Монгол Улсын энэ хууль, шүүхийн салбарт цахимжуулах тэр дундаа АТГ, шүүхийн цахим шинэчлэл гэх мэт талбарт бол энэ ажлууд эхлээд явж байгаа.

Цахим эрүүл мэндийн асуудал дээр бол яг одоо ОУБ-ын төсөв юм уу, улсын төсөв бол байхгүй байгаа. Гэсэн хэдий ч Засгийн газраас бол Эрүүл мэндийн сайд бид 2-т үүрэг өгсний дагуу бол бид нар зөвхөн төсвийн мөнгө гэхгүйгээр хамтын ажиллагааны хүрээнд цахим эрүүл .../минут дуусав/

Ж.Золжаргал: Нэмэлт мэдээлэл өгөх юм уу. 2 номерын микрофон нээж өгнө.

П.Батбаатар: Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга Батбаатар. Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр бол 05 дугаар тогтоолоор хууль батлагдсантай холбогдуулаад авах арга хэмжээний тухай тогтоол батлагдсан. Тус тогтоолын 6 дугаар зүйл дээр бол төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах гэсэн ийм чиглэлтэй тогтоол гарсан. Энэ тогтоолын хүрээнд бол өнөөдөр 31 улсад 47 хурдан цэгийг, орон нутгийн хэмжээнд 256 хурдан цэгийг, сумууд ороод эхэлчихсэн. Үндсэндээ бол цаана нь 60, 70-аад сум үлдсэн байгаа. Нийслэлийн хэмжээнд бол нийт 103 цэг байна. Дүүргүүдээр нь хуваагаад үзэх юм бол Налайх, Багануур, Багахангай, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдийн бүх хороодод “хурдан” цэг орчихсон. Үндсэндээ иргэд бол төрийн үйлчилгээг заавал тодорхой цэгээс биш анхан шатны засаг захиргааны нэгж буюу хорооноос авах ийм боломж бүрдсэн. Тэгээд Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт бол энэ 12 дугаар сардаа орохоор ингээд ... /минут дуусав/

Ж.Золжаргал: Нэмээд та цаг авах уу. 2 номерын микрофон нэмээд хариулъя.

П.Батбаатар: Тэгээд Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт бол уулзалт ярилцлагаа хийгээд тохирчихсон. 12 сардаа орно. Сүхбаатар, Баянзүрх дүүрэгт бол 1 дүгээр сард ороод тогтоолын 6 дугаар зүйл бол бүрэн хэрэгжиж дуусаж байгаа гэсэн үг. Баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Дараагийн асуулт. Галбадрах гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ж.Галбадрах: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Эртээд би намынхаа бүлэг дээр нэг мэдээлэл хийсэн юм байгаа юм. Боловсролд оруулах хөрөнгө оруулалтыг мега төслийн хэмжээнд авч үзэх үндэслэл ба шаардлагын талаар гээд 30-аад минут ярьсан. Энэ дээрээ өнөөдөр үнэхээр улс орон хөгжье гэвэл боловсролоо 1 дүгээрт тавих ёстой. Өөрөөр хэлбэл хүний хөгжил байх ёстой. Хүн нь хөгжиж байж улс хөгжинө. Энийг хүн болгон, гишүүн болгон, сайд болгон, амтай болгон л ер нь бүгдээрээ ярьдаг. Тэгээд яг үнэн чанартаа бид нар боловсролоо хөгжүүлэе гээд тэргүүлэх салбарын хэмжээнд авч үзэж байна уу. Мөн тэрийгээ 1 дүгээрт тавьж байна уу гэдэг зүйлийг би асууж ярьж байсан юм байгаа юм. Тэгээд өнөөдөр үнэхээр чадахгүй байна. Үнэхээр сургалтын чанар бол маш хангалтгүй байна. Маш доогуур байна. Энийг дээшлүүлэхийн тулд бид нар хөрөнгө оруулалт хийх ёстой гээд энэ үндсэн дээрээс би бас Сангийн сайдаас асууя. Одоо Сангийн сайд маань гараад явсан байна. Тэгээд орлох хариулах хүмүүсийг нь үзье. Тэгээд би тэр ярьсан мэдээлэл дотроо бол бид нар даруй 157 сургууль шинээр барих хэрэгтэй байна. Энэ хаанаас гарч ирсэн бэ гэвэл энд хүүхдийн, суралцагчийн эрх маш ноцтой зөрчигдөж байгаа. Нэг бүлэгт 30 хүүхдээр сургуулиа барьдаг. 1 сургуулийг хамгийн ихдээ 1400 хүүхдээр барьдаг ийм норм байтал бид нар 40-өөс дээш гарчихсан 214 мянган хүүхэд 1800 сургуульд 1400-гаа билүү 1800-аас давчихсан сургуульд 320 гаруй мянган хүүхэд сурч байна гээд.

Тэгээд үүнтэй уялдуулаад тийм сургууль байгуулах, сургууль шинээр байгуулахтай холбоотой багш нарыг шинээр бэлтгэх хомсдол мэдээж одоо хомсдолтой байгаа цаашдаа хомсодно гэдэг үүднээс тооцоо гаргаж хэлж байсан юм. Тэгээд яавч боловсролд оруулах хөрөнгө оруулалтыг бүгдээрээ хасахгүй байя. Нэмье. Одоо энэ жилийн төсөл бол ингээд батлагдах гэж байгаа юм байна гээд ярьж байсан. Тэгээд өнөөдрийн шинэчлээд оруулж ирж байгаа төсөл дээр маань 150 тэрбум хасагджээ. Урсгал зардал нь 125 хөрөнгө оруулалт нь 27 тэрбум хасагдаад ороод ирж байна. Тэгээд энийг ямар үндэслэлээр хасаад байна. Одоо бүр тодорхой хэлэх юм бол Боловсролын зээлийн сан гээд тэтгэлэг өгдөг, багш мэргэжлээр сурдаг хүүхдэд өгдөг мөнгө энэ тэр орчихсон 17 тэрбум хасагдсан байна. ЕБС-ийн хувьсах зардал буюу гүйцэтгэлийн үр дүнгээс 58, СӨБ-оос 27,7 тэрбум ингээд хасагдсан байна. Тэгээд ямар зарчим, ямар үндэслэл бариад хасчхав. Энэ чинь эрсдэл дагуулахгүй юу гэдгийг Сангийн яамныхан нь бас асуух гээд байгаа юм. Үдийн цай хасагдчихаж байгаа юм. Тоног төхөөрөмж нь хасагдчихаж байгаа. Хүүхдийн хоол гээд цэцэрлэг нь хасагдчихаж байна л даа. Тэгээд энэ маань ийм хасаж болох зүйл үү. Жишээлбэл би анхны хэлэлцүүлгийн үеэс л санал болгоод яваад байсан юм. Одоо энэ НҮБ-ын нэг барилга байна л даа. 50 тэрбум гээд. Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар хурлын байгууламж барина гэсэн. Энэ ямар байгууламж юм гэдгийг асуумаар байна.

Ж.Золжаргал: Та нэмж авах юм уу.

Ж.Галбадрах: Тэгээд энэ ондоо ингээд бүтэн 50 тэрбум нь тавигдчихаад байгаа юм. Тэгээд энэ их мөнгөөр бол миний энэ яриад байгаа хасахгүйгээр цааш нь 2, 3 сургууль барьчих боломж байна.

Инновац, цахим бодлогын байнгын хорооныхонтойгоо холбогдуулж асуухад өнөө өглөөхөн бид нар манай дарга бас орсон. Бид хэд хүний эрхийн асуудлаар г өглөөний уулзалтад орлоо. Тэгээд энэ цахимын өртөлт, хандлага, ялангуяа технологи ашиглаж үйлдэгдэж байгаа жендерийн хандлага бол маш их хүчтэй хэмжээнд очиж, амиа хорлох хэмжээнд хүүхдүүд ирж байна. Энэ талаар боловсролын байгууллагатай, яамтай хэр хамтарч ажиллаж байна. Хүүхдүүдийн зөв зохистой цахим хэрэглээний талаар манайхан ямар бодлого баримталдаг юм, ямар төсөл хэрэгжүүлдэг юм. Багш нарын IT-ийн мэдлэгийг дээшлүүлэх, технологийн мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн ажилтнуудыг дээшлүүлэхгүй бол хэсэг бүлэг үүсгээд одоо үе тэнгийн дээрэлхэл гэж байдаг бол одоо цахим хандлага бол амиа хорлох хэмжээнд ирээд байна гэж өнөөдөр ярьж байна лээ л дээ. Энэ талаар ямар бодлого байдаг юм ... /минут дуусав/

Ж.Золжаргал: Баярлалаа. Яг хэлэлцэх асуудал дээр шууд холбоотой биш боловч тэр боловсролын суурь хөрөнгө оруулалт зардлын талаар Улсын Их Хурлын гишүүний хувьд Галбадрах гишүүн асуулаа гэж ойлголоо. Энэ дээр нь Сангийн яамнаас тодорхой хариулт өгнө үү гэж хүсье. Тэгээд дараагийнх нь бол цахим хөгжил боловсролын салбарын хамтын ажиллагааны талаар. Эхлээд тэгвэл цахим яамнаас хариулж байх уу. Сангийн яамнаас хүн байвал бэлдэж байгаарай.

Ц.Баатархүү: Зүгээр яах вэ мэдээлэл өгөхөд төсөв дахиж өргөн барихад бүх яамдын урсгал зардлаас ер нь бол 10 хувиар хасна гэдэг ийм бодлого барьсан учраас салбар болгон дээр хасагдсан үнийн дүн янз бүр харагдаж байгаа. Ингээд тэгшитгээд хассан. Энэ тэгшитгэж хассан зүйл нь зөв үү, буруу юу гэдэг дээр Улсын Их Хурлын гишүүдээс гарсан 4, 5 ажлын хэсэг одоо яг хуралдах гэж байна. Тэгээд би Галбадрах гишүүнийг маш зөв зүйтэй санал хөндөж байгаа учраас тэр ажлын хэсэг дээр бас орж санал энэ тэрээ өгөөрэй гэж хэлмээр байна. Энд нэг зүйлийг ер нь тодорхой хэлмээр байгаа юм. Төр төлөөлж байгаа 1 хүн очоод ОУБ дээр сэтгэл нь хөдлөөд Монгол Улсад ийм хурал, олон улсын хурал хийнэ гээд мэдэгдчихдэг. Өмнөх сайд маань КОП-26-г авна гээд ингээд мэдэгдчихсэн. Тэгээд дэлхийд мэдээлэл нь явчихсан. Авахаас өөр аргагүй байдалд орсон. Үүний наад захын зардал нь 50-100 тэрбумаар хэмжигдэж байгаа. Тэгээд яг Монгол Улсад ямар өгөөжтэй юм бэ гэдэг нь тийм тодорхой биш юм дээр Засгийн газрын гишүүд цөлжилтийн эсрэг ийм юмны эсрэг олон улсын хурлыг Монгол авна гээд явдаг шүү энийг бас Улсын Их Хурлын гишүүд, ер нь Засгийн газрын гишүүд бүх түвшиндээ бас цаашдаа анхаарах ёстой юм байна гэдгийг бол Галбадрах гишүүн хэлсэн учраас хэлье.

Боловсролын ерөнхий газарт энэ хүүхдүүдийг цахимаар дээрэлхэх асуудлаар манай агентлаг Боловсролын Ерөнхий газар 2 бол хамтарч ажиллаж байгаа. Энэ дээр бол бид нар ажлын хэсэг гаргасан. Хүүхдүүдэд зориулсан хортой болон ийм ноцтой ийм кодууд ийм мэдээлэл ямар байна вэ гэдэг дээр манай яам хуулийн яамтай хамтарсан ажлын хэсэг гаргаж ажиллаад, тэгээд энэ хамтын ажиллагаа явж байгаа. Ер нь Боловсролын яам, Эрүүл мэндийн яамтай бид нар хамтарсан байдлаар үр дүн гаргахгүй бол аль нэг яам нь дангаараа яваад бас тодорхой 100

хувь үр дүн гарахгүй юм байна лээ. Бүх салбар хоорондоо уялдаатай болсон юм байна. Бие биеэ дэмжих шаардлагатай болсон юм байна гэдэг ийм дүгнэлтэд хүрсэн. Тэгээд тодорхой бас үр дүнгүүдийнхээ талаар Батбаатар дарга хариулаад өгөөрэй.

Ж.Золжаргал: 2 номерын микрофон нээж өгнө үү.

П.Батбаатар: Гишүүний асуултад хариулъя. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар бол ерөнхийдөө цахим ур чадварын сургалтыг 21 аймагт улсын хэмжээнд зохион байгуулж байгаа. Үндсэндээ өнгөрсөн 1 жил 6 сарын хугацаанд бид нар 90 гаруй мянган төрийн албан хаагч, иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сургалтыг зохион байгуулаад явж байгаа. Сургалтын агуулга дээр бол Монгол Улсын Засгийн газраас 2024 онд баталсан бүтцийн хүрээний боловсролтой холбоотой, цахим боловсролтой холбоотой 141 дүгээр тогтоол гарсан. Тус тогтоолын хүрээнд бол төрийн албан хаагч нарт төрийн үйлчилгээтэй холбоотой сургалтуудыг, иргэдэд бол цахим ур чадвар, цахим засаглал, мөрийтэй тоглоом, цахим залилан, кибер аюулгүй байдлын энэ асуудлуудаар сургалтыг 90 гаруй мянган хүнд хийгээд явж байгаа. Энэ бол цаашаа үргэлжлээд ингээд явах юм. Бид бол сая өнгөрсөн хугацаанд Боловсролын ерөнхий газартай хамтраад орон нутаг дахь боловсролын хэлтэс, насан туршийн боловсролын төв .../минут дуусав/

Ж.Золжаргал: Галбадрах гишүүний асуусан асуулттай холбоотой Харилцаа холбооны зохицуулах хорооноос энэ чиглэлээр ямархуу байдлаар ажиллаж байгаа бол. Тэгээд 5 номерын микрофон нээж өгнө үү.

Б.Мягмарнаран: Сайн байна уу. “И-Монгол Академи” УТҮГ-ын захирал Мягмарнаран.

Харилцаа холбооны зохицуулах хороо, яам, салбарын байгууллагууд хамтраад хүүхэд хамгааллын чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулж байгаа. Нэг нь болохоороо ekids.mn цахим хуудсыг хөтөлж байгаа. Үүн дээр болохоор НҮБ-ын Монгол дахь Хүүхдийн хүүхдийн төв хамтраад яг контентуудыг оруулж байгаа. Энэ дээр мэргэжлийн нийтлэгч контент бичдэг, хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг хүмүүсийн нийтлэл болон пост зургуудыг оруулж байгаа. Энэ постер зураг мэдээллийг бас И-Монгол дээр насанд хүрсэн хүнд л зориулсан бол одоо хүүхэд нэвтрэх боломжтой болгочихсон. Тэр дээр давхар оруулаад хүүхэд цахим орчинд яаж өөрийгөө зөв зохистой хамгаалах вэ талаарх зөвлөмжийг өгдөг байдлаар контентуудыг оруулсан байгаа.

Мөн Харилцаа холбооны зохицуулах хороо дээр интернэтийн үйлчилгээ эрхлэгчид .../минут дуусав/

Ж.Золжаргал: 5 номерын микрофон нээж өгье.

Б.Мягмарнаран: Парентал контрол буюу интернэтийн үйлчилгээ авч байгаа байгууллагадаа хүсэлт гаргаад, эцэг эхийн хяналтыг идэвхжүүлэх боломжийг нээж өгсөн. Өөрөөр хэлбэл эцэг эх болон гэртээ интернэтийн үйлчилгээ эрхлэгч гэрийнхээ интернэт дээр шаардлагатай гэвэл хүүхдийнхээ интернэтийг хязгаарлах боломж бол гарчихсан байгаа. Баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Сангийн яамнаас хариулт өгөх хүн байхгүй байна тээ. Байна уу. 5 номерын микрофон.

Б.Ганзориг: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг гишүүний асуултад хариулъя. Боловсролын салбарын хөрөнгө оруулалт бол ирэх жилийн төсвийн хөрөнгө оруулалтын салбарууддаа бол дээрээс нь 2-т орчихсон явж байгаа. Зам, тээврийн салбарын дараа нийтдээ 472 тэрбум төгрөгийн санхүүжилтийг санхүүжих дүнгийн хувьд бол орсон байгаа. Яах вэ, энэ 472 тэрбум төгрөгийн хүрээнд нийтдээ 89 сургууль. Өмнө нь бол 92 сургууль байсан. Яах вэ бид нар энэ төсвийн төсөл дээр гэрээ байгуулаагүй төслүүдийг 12 сарын 1-ний байдлаар оруулаагүй. Гэрээгүй, хөрөнгө оруулалтын ажлуудыг бууруулсантай холбоотойгоор 89 сургууль болсон байгаа. Өмнө нь бол 62 цэцэрлэг барихаар төлөвлөсөн байсан. 3 ажил бас гэрээ нь байгуулагдаагүй учраас 12 сарын 1-ээр хасаад нийтдээ 69 цэцэрлэг болсон байгаа. Тэгэхээр ер нь бол боловсролын салбар дахь хөрөнгө оруулалт бол нийт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бол зам тээврийн салбарын ард орж байгаа 2 дахь том хөрөнгө оруулалтыг аваад явж байгаа салбар байгаа.

Ж.Золжаргал: Хассан ч гэсэн том байгаа л гэж хэлээд байх шиг байна. Ер нь бол хасах нь буруу юм гэсэн байр суурийг илэрхийлж байгаа байх. Тийм ээ. Манай техникийнхэн 4 минут хуулийн дагуу хариулт хэлэх ёстой. 4 хүртэл тэгээд хугацаа нь 1 минутаар яваад байна шүү. Энэ дээрээ анхаараарай. Та тодруулах юм уу. Галбадрах гишүүн тодруулга.

Ж.Галбадрах: Тэгээд Сангийн яамныхан маань ийм л буруу ойлголттой л яваад байгаа юм л даа. Ер нь бид нар чинь ингээд 2 дугаарт хөрөнгө оруулалт хийчихлээ. Ер нь сүүлийн 10 жил бид нар 600 сургууль байгуулсан гээд Жавхлан сайд хэлсэн юм. Тэгээд би Жавхлан сайдад та буруу ойлгоод байна. Өргөтгөл бариад 600. Хүн ам маань өсөөд байгаа. Тэгээд 40 гарсан хүүхэдтэй сургууль 214 мянган хүүхэд сураад байна шүү дээ. 1 бүлэгт. Тэгээд энийг их сайн бодож Сангийн яамнаас бол ирэх он гараад ер нь салахгүй л гэж бодож байгаа. Энэ зөндөө тооцоо хийчихсэн байж байгаа. Зүгээр энэ юуныхнаас асуучихмаар байна. Цахим хөгжлийн яамныхнаасаа. Энэ веб сайт энэ тэр хакердуулаад байгаа. Би нөгөө анх очихдоо л хэлж байсан. Манай сургуулийн веб сайт хакердуулчихсан чинь ийшээ хандаад хандаад ерөөсөө 3 7 хоног бараг сар дөхсөн. Тэгж байж нэг больсон. Дандаа насанд хүрэгчдийн киног шинэчлээд л 1 хоноод л, 2 хоноод л шинэчлээд тавьчихдаг юм байна лээ. Энэ тал нь сургуулиудын веб сайт хэр хамгаалагдсан байдаг .../минут дуусав/

Ж.Золжаргал: Цахим сургалт, сургуулиудын веб сайтын талаар 4 номерын микрофон нээж өгнө үү.

Ц.Баатархүү: Кибер халдлага зөрчил ер нь Монгол улсын тулгамдсан асуудал болж байгаа. Сая нэр бүхий эмнэлгийн асуудал дээр бүгдээрээ мэдээлэл авсан. Сургуулиудын асуудал 2 шалтгаан байгаа юм.

1 дүгээрт энэ 2023 онд шиг санаж байна. 207 дугаар тогтоол Засгийн газраас гарсан. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй газруудын жагсаалтыг баталсан. Тэр жагсаалтад орсон байгууллагуудыг Тагнуулын ерөнхий газар, Кибер зөрчил халдлагатай тэмцэх нийтийн төв, Батлан хамгаалахын дэргэдэх Киберийн төвүүд бол хамгаалж урьдчилан сэргийлэх ажлыг хийдэг. Гэтэл бол зарим газрууд бол

тэр жагсаалтад өөрсдийнхөө харьяаны байгууллагуудыг оруулаагүй. Тэгэхээр хуулиараа бол мэдээлэл хариуцагч байгууллага өөрөө бол түүнийгээ хариуцах ёстой болчихоод байгаа юм. Гэсэн хэдий ч бол яам, Тагнуулын төв ... /минут дуусав/

Ж.Золжаргал: 4 номерын микрофон нээж өгье. Энэ цаг буруу яваад байна шүү. Техникийн ажилтнууд цагаа засаж өгөөрэй.

Ц.Баатархүү: Ингээд урьдчилан сэргийлэх байдлаар бол ажиллаж байгаа. 1 дүгээрт энэ кибер хамгаалал гэдэг дээрээ мэргэжлийн хүмүүс төрийн байгууллагууд, тэр дундаа энэ сургуулиуд дээр бол байдаггүй юм байна. Байх боломж бололцоо ч их бага юм байна. Түүнийг нь цалинжуулах тодорхой төсөв өртөг байхгүй юм байна. Тэгэхээр бид нар Засгийн газрын хурлаар саяхан ямар тогтоолын төслийг батлуулсан бэ гэхээр мэдээлэл хариуцаж байгаа тэр дундаа хувийн мэдээлэл, эмзэг мэдээллийг хариуцаж байгаа бүх байгууллагууд бол кибер аюулгүй байдлын мэргэжилтнийг заавал ажиллуулах ийм тогтоол гаргасан. Тэгэхгүй бол ингээд мэргэжлийн хүн байхгүй учраас админыхаа эрхээр байдаг юм уу алдаад, кибер зөрчил халдлага ороод, тэнд байгаа хувийн эмзэг мэдээллийг нь аваад элдэв янзын байдлаар олон нийтэд дэлгээд, ингээд кибер зөрчил, халдлагын асуудал бол ингээд тасрахгүй байгаа юм. Үүнтэй холбогдуулаад манай кибер зөрчил халдлагатай тэмцэх .../минут дуусав/

Ж.Золжаргал: 5 номер дээр нэмэлт хариулт өгнө.

Ч.Золбаяр: Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Золбаяр байна. Нэмж хариулахад бол Кибер аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаас энэ төсвийн ангиллыг бий болгох гэдэг асуудлыг ярьсан. Дээр нь бол кибер аюулгүй байдлыг хангах албан тушаалтныг тодорхой бүх байгууллагууд дээр байх ёстой гэсэн шийдвэрийг гаргаад, холбогдох байгууллагуудаар уламжлаад бид нар энийг хийгээд явж байгаа. Энэ веб сайтын кибер халдлага ер нь аливаа нэг байгууллагуудын кибер халдлагад өртсөн байна гэдэг учир шалтгаан нь бол ер нь цэвэр нэг ганц технологийн юм уу 1 байгууллага хангах гэдэг талаасаа явахгүй, нийтээрээ өргөн хүрээнд хамтарч ажиллаж байж энэ нь шийдэгдэх гэсэн ийм байдал нь бол дэлхий нийтэд тодорхой болсон байж байгаа. Тэгэхээр бол боловсролын системийн байгууллагууд юм уу, манай хувийн хэвшлийн байгууллагууд болон иргэд бол кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвөөс тусламж үйлчилгээгээ аваад, мөн мэдээллийн аюулгүй байдлын болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээгээ хийлгэсний үндсэн дээр манай өөрийн .../минут дуусав/

Ж.Золжаргал: Нэмэх үү. 5 номер нэмэлт цаг.

Ч.Золбаяр: Ямар эрсдэлтэй байна мөн бид цаашдаа юун дээр анхаарах вэ гэдэг зөвлөмжийг аваад цаг тухайд нь энийгээ хэрэгжүүлээд явахад бол бас халдлагаас нэлээдгүй хэмжээнд урьдчилан сэргийлэгдэх ийм боломж байж байгаа. Зөвхөн өнгөрсөн 7 хоногийн байдлаар манай яг кибер аюулгүй байдлын зөвлөл дээр ирсэн мэдээллээр харахад бол өнгөрсөн 7 хоногт 68.565 удаагийн халдлагын шинж чанартай ийм мэдээлэл солилцооны үйл ажиллагаа Монгол Улсаас гадагшаа явагдсан байна. Энэ нь бол 38 ISP компанийн 8,098 IP хаяг дээр гарчээ гэсэн ийм статистик байгаа. Энэ үзүүлэлт бол 7 хоногийн өдрөөсөө шалтгаалаад ингээд хувьсаж байдаг. Гэхдээ Монгол Улсын хэмжээнд сүүлийн 1

жилийн хугацаанд бол энэ маань ерөөсөө буурахгүй байгаа. Энэ үйл ажиллагаанаас бол ердөө бид нар 8-5 хувийг нь л бид нар тодорхой хэмжээний халдлага мөн байна гэдгийг илрүүлээд, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байгаа. Бусдууд нь бол сэжигтэй тохиолдол гэдэг байдлаар ингээд тэмдэглэгдээд явж байгаа учраас энэ бол нийтээрээ бүх байгууллагууд кибер аюулгүй байдал дээрээ нэгдэж, тодорхой хэмжээний ... /минут дуусав/

Ж.Золжаргал: Нийтээрээ анхаарах хэрэгтэй байна гэж байна. Холбогдуулаад асуултаа асуучихъя. Би бас сүүлд нь асууя гэж бодож байсан. Кибер аюулгүй байдлын асуудал байна. Сүүлийн үед их анхаарал татаад, угаасаа ч нөхцөл нь хүнд байгаад байгаа тийм ээ. Тэгээд энэ төсөв дээрээ та нар маань Кибер зөвлөлийн төсвөөс 159, нийтийн төвөөс 388 гээд хасахтай орж ирсэн. Тэгэхээр нөгөө нийтийн төв дээр сул байгаад байгаа техникийн чадамжаа олон улсын төслөөр хэрэгжүүлэх тийм төсөл байсан шүү дээ. Тэр маань хэрэгжиж байгаа юм уу. Энэ төсвүүдээ хасчихаар нөгөө кибер аюулгүй байдлын эсрэг чадамж маань сулрах уу, үгүй юу. Энэ дээр нэг тайлбар хэлээч. 5 номер.

Ч.Золбаяр: Сангийн яамнаас Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны төсвөөс бол 159 сая төгрөгийг бууруулсан байдлаар Сангийн яамнаас санал ирсэн байна лээ. Энэ бол нийтлэг жишгээрээ бүх зардлуудыг танаж байгаа гэдэг агуулгаар орсон байгаа боловч ер нь бол яг бодит байдал дээр бол ажлын албан дээр илүү цаашдаа бид нар нийтлэг арга хэмжээ авах сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах чиглэл дээр бол зардлын шаардлага бол байгаа. Нийтийн төв дээр байгаа тоног төхөөрөмж чадамжийн асуудал дээр ярих юм бол энэ маань 2 төсөл хэрэгжиж яваа. 1 нь бол Ухаалаг засаг төслийн хүрээнд бол 1 багц нь бол Улсын хэмжээний нийтийн төв дээр суурилагдах кибер аюулгүй байдлын чадамжийг дээшлүүлэх гэсэн ийм төсөл маань эхлээд үе шаттайгаар явж байгаа. Энэ маань Дэлхийн банкны төсөл байгаа.

Нөгөө төсөл маань болбол Жайка ОУБ-ын дэмжлэгтэйгээр хүний нөөцийн чадамжийг дээшлүүлэх гэсэн ийм чиглэлийн сургалт, судалгааны ажлыг хөгжүүлэх ийм төсөл явж байгаа. Энэ 2 төсөл маань бол гадаадын зээл тусламжийн хүрээнд бол явагдаж байгаа учраас энэ бол бүрэн хэрэгжиж бол дуусаагүй, үйл ажиллагаа нь бол явагдаж байгаа. Нийтийн төв дээр төсвийн асуудлаар бол Жавхлан захирал өөрөө тайлбар өгөх нь зөв байх.

Ж.Золжаргал: 5 номер дээр нэмэлт хариулт.

С.Жавхлан: Сая Золбаяр дарга үндсэндээ хэлчихлээ дээ. Гол нь нөгөө Сангийн яам нийтээр нь хасаж байгаа болохоор л нийт дүнгээрээ хасагдаж байна. Ер нь бол сая Золоо дарга хэлчихлээ. Манайх тэр 2 төсөл бол явж байгаа. Тэр 2 төслөөр хөрөнгө оруулалт хийгдэж байгаа. Тэгэхдээ нөгөө Засгийн газрын тогтоолоор эдийн засгийн ангилал өөрчлөгдчихөөр бас бусад байгууллагууд үндсэндээ дажгүй төсөв тавьчихдаг болох байх. Яг өнөөдрийн байдлаар бол манай төв бол ямар нэгэн хөрөнгө оруулалтын зардал бол улсын төсвөөс авсан юм байхгүйгээр явагдаж байгаа. Ирэх онд бол одоо байгаа төсөвтөө харьцангуйгаар тохируулаад ажиллана гэж дүгнэхээр үндсэндээ бодит байдал дээр бол одоо байгаа хүчин чадлаа нэмэх боломж бол бараг байхгүй.

Байнгын хорооны дарга очиж үзсэн. Тэгэхэд нөгөө хүн хүч маань жоохон дутуу байсан хэвээрээ үйл ажиллагаа маань явагдана. Тэгэхдээ бусад

байгууллага олон улсын байгууллагуудынхаа тусламжаар илүү үйл ажиллагаа сайжрах болов уу л гэсэн бодолтой байгаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Кибер дээр ер нь бүгдээрээ айхтар анхаарал хандуулж бас тусдаа ярилцах хэрэгтэй болох байх. Тийм ээ. Ингээд дараагийн асуулт асуух гишүүн Ундрэм гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ч.Ундрэм: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Эхлээд Сангийн яамнаас асуух гэсэн юм. Энэ Засгийн газрын тусгай сан гээд 22 сан байгаа л даа. Тэгээд энэ дээр хамгийн их миний өнгөрсөн 4 жил ч гэсэн зөндөө яриад бүтээгүй Нийгмийн халамжийн сан байна. 2,5 их наяд. Тэгээд сая энэ шинэ төсвөөр яах вэ 31,4 тэрбум хасагдсан гээд энэ та бүхний өгсөн материал дээр байна л даа. Тэгэхээр бид нар энэ халамжийн бодлогоо шинэчилмээр байна. 3 төрлийн, 4 төрлийн халамж зэрэг авдаг бараг 500 мянга, 600 мянган хүн байдаг Монголд. Энийг бид нар цэгцлэх ёстой. Энийг хэзээ цэгцлэх юм. Энэ мөнгөнөөсөө хасаад харин оронд нь энэ Боловсролын зээлийн сан гээд багш нарыг бэлддэг, тэтгэлэг өгдөг энэ 2,5 их наядын хажууд хамаагүй бага мөнгө шүү дээ. Энэ боловсролын зээлийн сангаа ядаж хасахгүй нэмдэггүй юм гэхэд. Тэгээд энэ халамжийн сангаасаа хасчхаж болдоггүй юм уу. Халамжаа цэгцэлж болдоггүй юм уу. Энэ Засгийн газар гэдэг асуулт байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаас энэ 2022 оны төсвийг хэлэлцэж байхад анх И-Монгол академи гээд байгуулагдаад, анх ингээд төсөв дээр зардал тавигдаад орж ирсэн. И-Монгол академи өнөөдөр яг хэдэн хүн ажиллаж байна. Ямар үр бүтээл гаргаж байна. Энэ академи ер нь Монгол Улсад өнөөдөр 1 номерын хэрэгтэй зүйл мөн үү, үгүй юу. Та юу гэж бодож байна. Энэ 1 дүгээр асуулт.

2 дугаарт төрийн үйлчилгээг зохицуулах газар гээд бас 8,5 тэрбум төгрөгийн төсөв гээд энэ Байнгын хорооноос гаргаж өгсөн. Нөгөө материалтайгаа бол зөрөөд байна шүү. Бүх энэ дүн чинь. Тэгэхээр энэ газар чинь бас юу хийдэг юм бэ гэж асуумаар байна.

3-д нь энэ өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан гээд одоо жил болгон энэ асуудал бас олон нийтийн сүлжээнд тавигддаг. Өнгөрсөн жил энэ өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангаас яг ямар ямар телевиз хэдэн төгрөгийн санхүүжилт авсан бэ. Тэрийг нээлттэй ер нь зарласан бичиг баримт Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хангаад нийтэд зарлачхаж болох уу гэсэн ийм асуултууд байна.

Ж.Золжаргал: Эхлээд Сангийн яам руу хандсан асуултаас нь хариулаад явах уу. Тэр өргөн нэвтрүүлгийн сангаас авсан телевизүүдийн нэрсийг тэр хооронд бэлдэж байгаад боломжтой бол шууд нэрлээд өгчихсөн нь дээр байх. 5 номерын микрофон. Сангийн яамны Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Санжаадорж, Сангийн яах. Гишүүний асуултад хариулъя. Халамжийн зардлаас нэмж бууруулаад, зөрүүлээд Боловсролын зээлийн сангийн зардлыг нэмэгдүүлж болох уу гэж асууж байна. Санал гаргах эрх нь бол танд энд байгаа.

Ж.Золжаргал: Хэдэн номер вэ. 4 номер Баатархүү сайд.

Ц.Баатархүү: Ундрам гишүүн маань яг энэ дижитал шилжилт хийж байгаа чухал байгууллагуудыг цаашид юу хийх гэж байна вэ гээд нэлээн стратегийн суурь шинжтэй асуудлыг хөндөж байна.

1 дүгээрт өргөн нэвтрүүлгийн сан бол өнгөрсөн жил байгуулагдсан. Байгуулагдаад 1,8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс хуваарилсан боловч өргөн нэвтрүүлгийн сангийн журам өөрөө телевизүүдэд хуваарилахад хугацааны хязгаарлалтыг тавьчихсан байсан. 1 дүгээр улиралд багтаан өргөн нэвтрүүлгийн сангийн мөнгийг телевизүүдэд өргөн нэвтрүүлгийн сан гэдэг маань бол Монгол хүүхдүүдэд зориулаад эх оронч үзэл санааг гаргасан ийм контент үйлдвэрлэлийг дэмжих сан юм байна лээ. Тэгээд 1 ч төгрөг зарцуулж чадаагүй. Шалтгаан нь бол журмын зохицуулалт нь ойлгомжгүй байсан. Тийм учраас өнгөрсөн Засгийн газрын хурлаар өргөн нэвтрүүлгийн сангийн журмыг шинэчилсэн. Энийг шинэчилснээрээ бол өндөр хөгжилтэй улс орнуудад жишээлэх юм бол Солонгос улсад байдаг шиг Пороро гээд хүүхэлдэйн кино шиг улс даяараа нэг ийм эх оронч үзэл санааг харуулсан хүүхдийн танин мэдэхүйн контент үйлдвэрлээд, тэрийгээ л дэмжих бодлоготой сан юм байна лээ. Байгуулагдаад 1 жил болсон. Тэгээд бид нар бол ямар нэгэн байдлаар зарцуулсан зүйл байхгүй гэдгийг албан ёсоор хэлье.

2 дугаарт нь И-Монгол Академийн тухай асууж байна. И-Монгол академи маань бол байгуулагдаад төрийн бүхий л үйлчилгээ 1200 орчим үйлчилгээг үзүүлж байгаа. Зүгээр И-Монгол академи маань өөрөө Зөвшөөрлийн тухай хууль, бусад хууль тогтоомжтой холбогдуулаад төрийн үйлчилгээг төлбөргүй үзүүлж байгаа учраас улсын төсвөөс татаас аваад байгаа юм шиг харагддаг. Хэрвээ И-Монгол академи цаашдаа зарим нэг үйлчилгээг хураамжтай, төлбөртэй болгох юм бол улсын төсөв гэхээргүй улсын төсөвт орлого төвлөрүүлдэг байгууллага болно. Энэ завсрынхаа үе шатыг бол давсан.

2 дугаарт И-Монгол академи бол иргэн ороод би барилгын зөвшөөрөл авъя гэхэд та ийм, ийм үйлчилгээ авна шүү гэдгийг хиймэл оюун цаанаас нь 1 дүгээрт энэ, 2 дугаарт энэ, 3 дугаарт ийм гэдгийг шууд хэлж өгдөг болно. Жишээлэх юм бол би 8 нэрийн дэлгүүрийн зөвшөөрөл авъя гэхэд та ийм 11 зөвшөөрөл авах юм байна. Нэгийг нь энэ, 2-ыг нь энэ гэж санал болгодог байдлаар өөрчлөхөөр бол бид нар ажиллаж байгаа И-Монгол академи бол Монгол Улсын төрийн дэргэдэх хиймэл оюун ухааны их өгөгдлийн төв болох ийм стратегийн зорилттой ажиллаж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье.

3 дугаарт нь бол манай агентлагийнхан нэмээд бас тодруулаад хэлчхээрэй. Агентлаг бол энэ төрийн үйлчилгээг орон нутагт, сумд, багт “Хурдан” цэгээрээ дамжуулж хүргэдэг төрийн үйлчилгээг тэр дундаа орон нутаг алслагдсан бүс нутагт хүргэдэг ийм үйл ажиллагааг явуулж байгаа. 2022 онд байгуулагдсан. Манай салбартай холбоотой байгууллагууд бол ер нь 2022, 2023 онд байгуулагдсан ийм институцүүд байгаа гэдгийг хэлье.

Ж.Золжаргал: 2 номерын микрофон нээж өгнө үү.

П.Батбаатар: Ундрам гишүүний асуултад хариулъя. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын 499 дүгээр тогтоолоор байгуулсан байдаг. Тус агентлагийг байгуулахдаа бол УБЕГ, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар гэх

мэт 5 байгууллагаас тус бүр 1 орон тоог шилжүүлж, улсын төсөвт нэмэлт зардал гарахгүйгээр энэ агентлагийг байгуулсан байдаг ийм түүхтэй. Агентлагийн хувьд ямар үйл ажиллагааг хийж байна вэ гэхээр 1 дүгээрт бол төрийн үйлчилгээг цахимжуулахтай холбоотой процесс инженерчлэлийн ажлыг бол холбогдох байгууллагуудтай хийж эхлээд ажиллаж байна.

2 дугаарт бол яах вэ, бид нар сая өнгөрсөн хугацаанд 21 аймгаас төрийн үйлчилгээнүүдийг ер нь тооллоо л доо. Тэгээд бид бол тооны хувьд нийт 18 аймгаас өнөөдрийн байдлаар 1044 байгууллагын 6391 үйлчилгээг иргэдэд хүргэж байна гэсэн ийм тоо байгаа. 36 агентлагийн 755 үйлчилгээг хүргэж байна гээд. Энэ дээр бол ТӨК-ууд бусад зарим газрууд бол одоогоор ороогүй, судалгааны түвшинд хийгдээд явж байгаа. Үндсэндээ 8, 9 мянган төрийн үйлчилгээнүүд ингээд орчхоод байгаа. Энийг бол цэгцлээд үйлчилгээ мөн, бишээр нь ялгаад, шаардлагатай үйлчилгээ биш гэдгийг нь бол аймгийн иргэдийн Хурал ч юм уу, аймгийн шийдвэр гаргах түвшинд зарим байгууллагуудыг болиулахгүй бол энэ тоо нэлээн өндөр гарчхаад байгаа.

Дээрээс нь түрүүний асуусан цахим ур чадварын сургалтыг бол хийж байгаа. Орон нутагт бол 90 гаруй мянган хүнд хийчихсэн. Яагаад энийг хийгээд байна вэ гэхээр нийт Монгол Улсын насанд хүрсэн иргэд 2,6 орчим сая иргэн байгаа. Үүний одоо 1,9 сая иргэн нь бол И-Монгол гар утасны аппликэйшнд бүртгэлтэй. 700 мянга орчим хүн бол үйлчилгээ авч чадахгүй байгаа учраас хилийн боомтод, хилийн чанадад, алслагдсан бүс нутагт төрийн үйлчилгээг хүргэж явж байгаа. Энэ үйл ажиллагаа явснаараа бол цахим засаглалын индексээрээ бол алслагдсан бүс нутагт төрийн үйлчилгээг хүргэсэн энэ цахим ур чадварын сургалтыг хийснээрээ бол 193 орноос энэ жил бол Монгол Улс 46 дугаар байранд орсон ийм асуудлууд байна.

Дээрээс нь бол агентлагийн зүгээс төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн үйлчилгээг хувийн хэвшлийн этгээдээр гүйцэтгүүлэх чиглэлд Монгол шуудан, Цахилгаан холбоо, холбогдох хувийн аж ахуйн нэгжүүдээр төрийн үйлчилгээг гүйцэтгүүлээд эхэлчихсэн явж байгаа. Хариулт дууслаа.

Ж.Золжаргал: И-Монгол дээр 5 номер.

Б.Мягмарнаран: И-Монгол академийн захирал Мягмарнаран. Саяын И-Монголын нэвтрүүлсэн үйлчилгээ, түүнтэй холбоотой статистик мэдээллийг хүргүүлье. И-Монгол академи 2020 оны 10 сарын 2-нд анхны үйлчилгээг танилцуулсан байдаг. Үүнээс хойш бид бүхэн 59,3 сая үйлчилгээг иргэн хуулийн этгээд хүргэсэн. Өнөөдрийн байдлаар 1 сая 940 мянган хэрэглэгчтэй болсон байгаа. 86 байгууллагын 1255 үйлчилгээг цахимаар хүргэдэг. Үүнээс гадна бид нарын хувьд болохоор хүмүүс бол яг И-Монголиа гэж ойлгохоор нэг веб ч юм уу эсвэл мобайл аппликэйшн гэж боддог. Бид нар бол төрийн 29 системийг хариуцаж ажилладаг байгаа. Зөвхөн 2024 онд цахимаар авсан үйлчилгээ, тэрэнтэй холбоотой төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэн холбогдох байгууллагуудад төвлөрүүлсэн хэмжээг үзэх юм бол зөвхөн 2024 онд бид бүхэн 24 тэрбум төгрөгийн төсвийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Бид нарын хувьд болохоор ерөнхийдөө бол цахимжилтыг үндсэндээ дэмжиж ажилладаг. Наанаа үйлчилгээ үзүүлэхээс гадна бид нар төр, хувийн хэвшилд зориулсан сервисүүдийг хур системээрээ дамжиж хөгжүүлдэг. Одоогоор 806 сервисийг 500 гаруй төрийн байгууллага болон хувийн хэвшилд нийлүүлж ашиглаж байгаа. Одоогоор бол 3,2 тэрбум хурын

сервисийг иргэн, хуулийн этгээд дамжуулаад байна. Манай орон тоо бол 125 хүний орон тоотой. Жилийн төсөв 7,6 тэрбум орчим байгаа.

Ж.Золжаргал: Дараагийн асуулт Мөнхбат гишүүн. Уучлаарай. Ундррам гишүүн тодруулга хэлье.

Ч.Ундррам: Энэ И-Монгол академи бол их мундаг болох юм байна гэж ойлголоо. Болох гээд орлого төвлөрүүлээд чухам улсад мөнгө авчраад байх ийм газар болох юм байна гэж сая хэлж байна. Тэгэхдээ 1 ийм зарчим байгаа шүү Баатархүү сайд аа. Төр, хувийн компани гүйцэтгэх юмыг өмнүүр нь орж хийж болохгүй шүү. Хувийн компаниуд Монгол компаниуд хийж чадах юмыг нь өөрсдөөр нь хийлгээрэй. Битгий урдуур нь ороод би хийнэ бүгдийг нь гээд гүйгээд байгаарай. Хувийн компаниуд хийж чадахгүй юм байвал яах вэ, та тэр мундаг ийм академиараа хийлгэдэг юм байгаа биз.

Энэ өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан тэгвэл мөнгө төгрөгийг нь угаасаа ч зарцуулаагүй юм байна. Тэгээд одоо дахиад энэ төсөв дээр тавигдчихсан байгаа мөнгө нь зарцуулагдах зүйл нь эх оронч үзэл санааг суулгах контент гэнэ. Тэгэхээр .../минут дуусав/

Ж.Золжаргал: Ундррам гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ч.Ундррам: Энийг тэгэхээр зарчмын зөрөөтэй санал гаргаад боловсролын салбарт ялангуяа энэ цэцэрлэг, сургуулиудад маш олон зардлууд дутаж байна. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний мөнгийг нь хүртэл хасчихсан. Одоо тэгээд тэр багш нарыг цалингүй байлгах гэж байна л даа. Тэгэхээр ийшээ шилжүүлэх зарчмын зөрөөтэй саналыг одоо гаргах гэж байна. Тэгээд эрхэм гишүүдээ дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Энэ асуудал зарчмын зөрүүтэй санал дээр орж ирэх үед нь бүгдээрээ бас үргэлжлүүлэн хэлэлцүүлье. Дараагийн асуулт Мөнхбат гишүүн.

Ц.Мөнхбат: Манайх төсөв эргэж орж ирж байгаатай холбогдуулаад нөгөө үндэсний хиймэл дагуул хөөргөх гэж байсан төсөл маань больсон. Тийм ээ. Франц улстай хамтраад. Энэ дээр манай бас энэ мэдээлэл технологийн ойлголттой мэргэжлийн хүмүүсээс бас янз янзын саналын зөрүүтэй зүйлүүд ч яригдсан. Тэгээд энэ дээр үндэсний хиймэл дагуул нөгөө Францтай ярьж байсан шийдэл бол ингээд больчих шиг боллоо. Та бүхэн ер нь юу гэж үзэж байна. Энэ хиймэл дагуулаа ер нь ингээд огт больж байна уу. Эсвэл өөр шийдлүүд хайж байна уу. Энэ дээр нэг ийм хариулт авмаар байгаа юм. Яагаад энэ үндэсний хиймэл дагуулыг сонирхоод байна гэхээр зэрэг сая түрүүн таны ярьсан энэ алслагдсан сум, суурин газруудад үүрэн холбооны сүлжээ оруулах, интернэтийн сүлжээ оруулахад бол хэрвээ энэ хиймэл дагуул хөөрсөн бол нэлээн их хэмжээний зардлыг хэмнэх, цаашлаад бид нар улс орны хувьд, бүс нутгийн хувьд цахимжих ийм бололцоонууд нээгдэнэ гэдэг ийм ойлголт байсан. Тэгээд энэ дээр та нар ямар шийдлүүд хайж байна. Тэгээд энэ Бүх нийтийн үүргийн сангаараа энэ алслагдсан сум, суурин газар үүрэн холбооны сүлжээ байгуулна гэж байна. Энэ ямар төсөвтэй, хэчнээнийг шинээр байгуулах юм. Танай яамны хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт дээр 36.1.4 дээр үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчдийн тоог 15 байсныг 29 болгох юм гэнэ. Энэ яг ямар тоо юм бэ. Юуг хэлж байгаа юм бэ гэдгийг ингэж асуух гэсэн юм.

Дараа нь яг үүнтэй холбогдуулаад ер нь бид нар 300, 400 саяар ингээд энэ багуудын холбоог шинэчлэхэд гар утасны сүлжээ хүргэнэ гэхээсээ илүүтэй интернэтийн сүлжээ нь бол илүү ач холбогдолтой байгаа. Энэ дээр өөр шийдэл байна уу. Арай хямд юм уу. Өөр шийдлүүд байна уу. Одоо нөгөө Старлинк ч юм уу тийм өөр шийдэл байдаг юм уу гэдэг нэг ийм асуулт.

3 дугаарт тэр түрүүн хүүхдүүдийн цахим хэрэглээтэй холбоотой эцэг эхийн хяналтыг эрчимжүүлэх гээд ийм асуудал хэдэн жилийн өмнө нэлээн идэвхтэй яригдаад, тэгээд одоо жоохон зогсчоод байгаа юм уу санагдсан. Яагаад гэвэл нийгмийн харилцаанд бас энэ сэдвийг хөндөхөөр нэг тиймэрхүү юм байдаг гэсэн. Тэгээд яг яадгийг нь бид нар бас сайн ойлгохгүй байна гэсэн тийм хандлага байдаг байхгүй юу. Иргэдийн дунд. Тэгэхээрээ зэрэг тэрэнд зориулсан ийм контент юмнуудыг дахиж хийж идэвхжүүлэх ийм боломжууд байна уу.../минут дуусав/

Ж.Золжаргал: Мөнхбат гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ц.Мөнхбат: Тэгээд би сая энэ өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан гэдэг энэ санг сая л сайдын мэдээллээс ойлголт авлаа л даа. Тэгээд энэ 2 тэрбум шахуу төгрөг ингээд л ашиглагдаагүй юм байна. Энэ жил дээр 1,7 тэрбум төгрөг тавигдсан юм байна. Тэгээд энд саяын энэ контентуудыг хийдэг зардал чинь хамаардаг уу, эсвэл өөр юм хийгддэг үү гэдэг.

Эцэст нь сая энэ аудитын дүгнэлт уншсан. Энэ аудитын дүгнэлтийг хэвлээд өгөх боломж бий юу. Тэгээд ийм хэдэн асуулт.

Ж.Золжаргал: Аудитын дүгнэлт дээр би хариулт өгчихье. Одоо хэвлээд өгнө өө. Хаанаас хариулах вэ. Баатархүү сайд. 4 номерын микрофон.

Ц.Баатархүү: Мөнхбат гишүүн бас их чухал суурь асуудлыг хөндөж байна. Үндэсний хиймэл дагуулын асуудал бол зогссон биш. Хэлэлцээрийн үе шат явж байгаа учраас Улсын Их Хурал дээр өргөн барихыг бол энэ жилдээ хойшлуулсан гэж ойлгох хэрэгтэй. Талс компанитай хамтраад Спайс бааз 4 мянга би гэдэг өндрийн хиймэл дагуулын хиймэл дагуулыг хамгийн найдвартай энэ пуужингаар хөөргөх энэ төсөл бол одоо хэлэлцээрийн шатад явж байна. Эцэслэн шийдвэр бол гараагүй байна. Тийм учраас хэлэлцээрийн шатад явж байгаа учраас 2025 оны энэ төсвийн төслөөс бол хойшлуулсан байгаа гэдгийг албан ёсоор хэлье. Та нэг зүйлийг өөрөө сайн мэдэж байгаа. Дэлхий даяар одоо интернэт бол зөвхөн гар утсан дээр аппликэйшн татах, гар утсан дээр интернэтийн үйлчилгээ авах гэхээсээ илүү аж үйлдвэрийн гол суурь болсон. Эрчим хүч 5 жи 2 бол орчин үеийн шинэ үеийн юу байдаг юм. Жолоочгүй машин, автоматжуулалт робот технологийн гол суурь болсон. Тийм учраас шилэн кабель Монгол Улсад 52 мянган км шилэн кабель байна. Шилэн кабелиар уулын орой дээр байдаг бид нарын нэрлэж байгаагаар хөдөлгөөнт холбоо, нэмээд үндэсний өндрийн хиймэл дагуул, нам орбитын хиймэл дагуул, ингээд Вайфай 6 ч гэх юм уу төрөл бүрийн хэрэгслээр хамгийн найдвартай чанартай ийм хурдтай интернэтийг иргэд, аж ахуйн нэгжид хүргэх бол зайлшгүй шаардлага байна. Уулын орой дээр байдаг бааз станцаар явах юм бол 28 мянган бааз станц хэрэгтэй байна. Монгол Улс бол гаднын хиймэл дагуулд жилдээ 10 сая долларыг төлж байна. Тэгэхээр нэгэнт бид нар бусад улсын хиймэл дагуулд мөнгө төлж байснаас өөрийн гэсэн удирдлагатай хиймэл дагуултай больё гэсэн үе үеийн мэргэжлийн хүмүүсийн санаачилга ч одоо бол ингээд бас хэвээрээ байгаа шүү гэдгийг нэмж хэлэх нь зөв байх.

2 дугаарт тэр өргөн нэвтрүүлгийн сан гэдэг дээр манайхан нэг зүйлийг зөв ойлгох хэрэгтэй юм шиг байгаа юм. Энэ бол телевизэд хуваарилж өгдөг бол мөнгө биш. Телевизийг дэмждэг бол мөнгө биш. Телевизүүдийг хүүхдийн агуулгатай, тэр дундаа дандаа ийм гаднын агуулга биш, яг энэ Монгол агуулгатай зөв соёлыг түгээсэн хичээл номоо хийхэд нь, эрүүл зөв амьдрахад нь, боловсролдоо цаг зарцуулахад нь, ном уншихад нь зориулсан энэ агуулга хийхэд нь дэмжлэг үзүүлдэг ийм зорилготой сан юм байна лээ шүү. Тэгээд өнгөрсөн жил зөвхөн тэр нэг журмын зохицуулалтаас болоод энэ үйл ажиллагаа зогссон. Журмын гацааг нь бол бид нар Засгийн газрын хурлаар бол шийдчихсэн байгаа гэдгийг дахиж тодруулж хэлэх нь зөв байх. Энэ бол Монгол хүүхдийн боловсролд зориулсан өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр хүргэдэг хичээл, ном гэж бас та бүхэн ойлгож болно гэдгийг хэлье. Баярлалаа. Нэмээд Золоо дарга хариулчих.

Ж.Золжаргал: 5 номерын микрофон нээж өгнө үү.

Ч.Золбаяр: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Үндэсний хиймэл дагуулын төсөл маань бол зогсоогүй, хойшилсон гэдгийг Баатархүү сайд бол хэллээ. Энэ маань бол Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу үе шаттайгаар процессууд нь явагдаж байгаа. 2025 оны хувьд бол 2024 ондоо арилжааны болон зээлийн хэлэлцээр маань батлагдаад Их Хурлаас соёрхон батлагдсан бол 2025 онд нөгөө санхүүжилт талдаа зээлийн асуудал маань ингээд тусгагдаад ороод явахаар байсан ийм асуудал байсан. Цаг хугацааны хувьд энэ маань хойшилсон учраас бид 2025 ондоо энэ бусад процессуудаа хангаад, Их Хурлаар мөн бид нар энэ зээлийн хэлэлцээрийг зурах болон мөн энэ зээлийн хэлэлцээрийг баталгаажуулах талаараа бол Их Хурлаар тодорхой шийдвэрүүд нь ороод батлагдвал энэ маань төсөлдөө тусгагдаад ингээд явна гэсэн үг.

Түрүүн таны таны хэлсэн энэ харилцаа холбооны болон интернэтийн сүлжээг шийдэх гэдэг тал дээр бол үндсэндээ Монгол Улсад бол хамгийн оновчтой технологийн шийдэл нь бол хиймэл дагуулын сүлжээ юм байна гэдэг дээр бол санал нэг байгаа. Гагцхүү нам орбитынх байх уу, дундынх байх уу, өндрийнх байх уу гэдэг дээр бол сүүлийн үед жоохон хэлэлцүүлгийн юмнууд бол гарсан. Гэхдээ энд анхаарах нэг асуудал байгаа. Нам орбитын хиймэл дагуулыг бид нар хөөргөөд одоогийн старлингийн системээр ашиглах юм бол бид нар шууд ашиглах бололцоо байгаа. Хилийн бүсийн оролцуулахгүйгээр. Гэвч энэ маань тодорхой хэмжээний урсгал зардалтай байгаа болохоор 15 жилийн хугацаанд манай үндэсний хиймэл дагуулыг хөөргөөд ашиглах энэ хугацааны төлбөрөөс бол 2-3 дахин хамгийн бага хэмжээгээр бодоход бол ийм өртгийн өндөр юутайгаар нийт манай зардал маань ингээд тооцогдож өртөг нь бол юугаараа гарах юм. Үндэсний хиймэл дагуулыг хөөргөснөөр бол бид нар хэрэглэгчдэдээ очиж байгаа үнэ тарифыг бол харьцангуй бага үнээр зөвхөн урсгал зардлаа ашиглалтын зардал дээр тулгуурлаад хамгийн хямд өртгөөр хөдөө орон нутгийн энэ тоон хуваагдлыг бууруулах гэдэг нэг зорилготой. Дараагийн зорилго нь бол төрийн байгууллагуудын болон манай иргэдийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн байгууллагуудын арын холболт буюу байк оффисын бүх анги, нэгж нэгтгэлүүдийг холбох энэ шуурхай холболтыг үүсгэх, онцгой байдлын холбоог үүсгэх гэсэн энэ чиглэлүүд дээр бол маш их давуу тал бий болно.

Гуравдугаарх нь бол хиймэл дагуултай болсноор бол бид нар дараа дараагийн шатан дээр энэ хиймэл дагуулаар бусад төрлийн хиймэл дагуулын сүлжээг ашиглах маш том шинжлэх ухааны ийм нээлт нь бол үүд хаалга нь бол

нээгдэнэ гэсэн ийм ач холбогдолтойгоор бол энэ төсөл маань хэлэлцэгдээд ингээд явж байгаа. Төсөл маань бол зогсоогүй үргэлжлээд явж байгаа. Ер нь цаашдаа болбол бид хиймэл дагуулын сүлжээгээр газар нутгийнхаа нийт 70 хувийг хаана ч явсан өөрөө тодорхой төхөөрөмжтэйгөө байх юм бол сүлжээнд хамрах тийм бололцоог бүрдүүлэх гэсэн ийм шийдэл дээр бол ажиллаад явж байгаа.

Ж.Золжаргал: Мөнхбат гишүүн тодотгол. Микрофон нээх үү. Мөнхбат гишүүний микрофон нээж өгнө үү.

Ц.Мөнхбат: Түрүүн тэр нөгөө сайдын 2025 оны хэрэгжүүлэх хөтөлбөр үр дүнгийн шалгуур үзүүлэлт дээр энэ 36.1.4 дээр үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоог нэмэгдүүлнэ. Суурь түвшин нь 15. Тэгээд одоо 29 болно гээд байгаа юм. Энэ 2025 оных. Энэ яг юуг хэлж байгаа юм бэ. 15 гэж ямар тоо тэгээд 29 болох гээд байгаа юм бэ гэдгийг.

Тэгээд ирэх онд ер нь энэ алслагдсан сум, суурин газар хэчнээн газар сүлжээ оруулахаар төлөвлөж байна вэ гэдэг ийм 2 асуулт.

Ж.Золжаргал: 5 дугаар микрофон нээж өгнө үү.

Б.Мягмарнаран: Алслагдсан багийн төвүүдийг харилцаа холбооны сүлжээ оруулахад 151 ерөнхийдөө цэгт сүлжээ оруулах ийм зорилт тавьж ажиллаж байгаа. Мөнхбат гишүүн 2022 онд 15 гээд ингээд нөгөө суурь түвшин нь дараагийн жилийн түвшнүүд нь төлөвлөгөөнийхөө дагуу 25, 26 27 гээд ингээд өссөн дүнгээрээ явж байгаа. Тэгэхдээ суурь 15 дээрээ нэмэх нь гэдгээр тооцоологдож явж байгаа. Энэ бол эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах хүрээнд гээд 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Алсын хараа 2050-ийн хүрээнд бол ингээд тооцооллууд нь хийгдээд бодлогын бичиг баримтууд дээр тус төсөв дээр туссан явж байгаа. Ер нь бол энэ жил 100 цэгийг сүлжээ оруулахаар зорьсон боловч харьцангуй бас нөгөө сум суурин төвөөс алслагдмал, техник эдийн засгийн хувьд, зураг төсвийн хувьд бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бас зарим ажлууд, багц ажлууд хэрэгжиж амжаагүй. Тэгэхээр ирэх жил .../минут дуусав/

Ж.Золжаргал: Мөнхбат гишүүний хөндсөн энэ асуудал дээр нэгэнт энэ сэдэв явсан учраас би та бүхэндээ бас нэг мэдээлэл өгье гэж бодлоо. Орон нутгийн интернэт хангамж, тэгээд л боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний цахим цахимжилт гээд энэ интернэтийн юу нь хүрдэггүй ийм асуудлуудыг өнгөрсөн зун Их Хурал эхэлснээс хойш л бид нар ярьсан шүү дээ. Чуулган дээр ч ярьж байсан. Сүүлд энэ Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаныхан бас тийм судалгаа явуулаад, байгууллагуудаас мэдээлэл аваад СЕХ, УБЕГ, нийтдээ 400 гаруй 420 орчим байна уу старлинг төхөөрөмж сонгуулиар ашигласан. Тэгээд ингээд харьяа яамныхаа юугаар тэр шүүхийн болон цагдаагийн байгууллагуудаар тараагдаад ашиглаж байгаа гэсэн ийм мэдээлэл бид нар авсан юм.

Нөгөө талаасаа Боловсролын яамнаас жишээ нь интернэтийн хангамж ямар байна вэ гэхээр зэрэг ер нь бол их асуудал байна. Дор хаяж 57 газар ийм хөдөлгөөнт байдлаар хялбархан шийдчих юуны өмнө хэрэгтэй байна гээд. Тэгээд яриад л яваад байсан гэтэл цаана нь хэдэн 100 ийм төхөөрөмж ашиглачихсан тэрийгээ ингээд хураачихсан байгаа. Тэгээд энийгээ тэр сургуулиудад, хөдөөгийн сургуулиуд ядаж аваад тавьчхаач гэдэг хүсэлтийг, саналыг Засгийн газар хүргүүлчихсэн байгаа юм. Тэгэхээр энэ дээр хэчнээн хэмжээний сул байгаа юм.

Тэр нь бас орон нутагтаа яаж ашиглаж болох вэ гээд нэг хариу гарах байх гэж бодож байна.

Үүргийн санг сая дурдсан. Алтан-Од дарга. Тэгэхээр үүргийн сангийн энэ 2025 оны төсөв дээр орж ирсэн байгаа шүү дээ. Энэ сангийн маань хэдэн хувь нь нөгөө компаниудын хөрөнгөөр, одоо хураамжаар, хэдэн хувь нь төсвөөс явж байна. Энэ талаар нэг мэдээлэл өгөөч. Энэ уг нь үүрэн холбоо эрхэлж байгаа энэ салбарт ажиллаж байгаа компаниудад хураамжаар бас бүрдүүлж байх ёстой. Товчхон тоо мэдээлэл өгөөч. 4 номер.

Ц.Баатархүү: Засгийн газрын тусгай сангуудтай харьцуулахад бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн мөнгө бол улсын төсвөөс 1 ч төгрөг авдаггүй. Харилцаа холбооны компаниудын ашгийн 3 хувиар бүрдүүлээд, компаниудын төлөөлөл, хяналтын зөвлөлөө байгуулаад, ажлын хэсгээ гаргаад, хаана энэ хувийн хэвшлүүдийн ашгийн тодорхой хувиар бүрдүүлсэн сангаар зайлшгүй харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэх вэ гэдгээ өөрсдөө шийдээд явдаг. Яам бол бодлогын хувьд Улсын Их Хурлын гишүүд орон нутгаас ирсэн саналыг тэр хяналтын зөвлөлд хүргүүлдэг. Хяналтын зөвлөл хуралдаж шийддэг ийм сан байгаа. АТГ бусад хууль, шүүхийн байгууллагууд бол энэ сангийн үйл ажиллагаанд тогтмол шалгалт оруулж, хяналт тавьж байдаг ийм сан байгаа. Тэгэхээр энэ бол 8,3 тэрбум харагдаж байгаа нь бол энэ жилийн дүн нь бол 5,3 тэрбумыг бид нарыг төвлөрүүлээд, өнгөрсөн жилийн 3,2 тэрбум төгрөгөө нийлүүлээд ингээд 8,3-даа та бүхэн зарцуулалт хийгээрэй гэсэн хязгаар тоог Сангийн яам тавьж өгч байгаа. Улсын төсвөөс 1 ч мөнгө байхгүй. Байхгүй.

Ж.Золжаргал: Үүргийн сан дээр улсын төсвөөс бол мөнгө байхгүй. Компаниудын хураамжаар 8,3 гэсэн тийм төлөвлөгөөтэй явж байгаа юм байна гэж. Пунсалмаа гишүүний микрофон нээж өгнө үү.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Засгийн газрын гишүүдээс асуулт асууя. Өнөөдөр ЖДҮ-лэлийг дэмжих сан, Цагаан алт, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо гээд бага хүүтэй зээл олгох төслүүд хэрэгжиж байгаа. Эдгээр бага хүүтэй зээлүүд төслүүд бүгд зээлээ олгож байна уу. Тасралтгүй байдал ямар байна вэ. Цаашлаад энэ төсөл хөтөлбөрт хамрагдсан бага хүүтэй зээл авсан аж ахуйн нэгжүүд төрийн ямар бодлогоор уялдаатай дэмжиж байгаа вэ. И-цахим худалдан авалт, импорт тарифын бодлогууд ямар түвшинд явагдаж байгаа вэ.

Цаашлаад бол Цагаан алт, хүнсний хувьсгалаас гадна бусад салбарууд жишээлбэл инновац, технологи, IT-ийн салбаруудыг дэмжих төрийн ямар бодлогууд байгаа вэ.

2 дахь асуулт нь болохоор сүүлийн үед мэдээллийн аюулгүй байдлыг дээшлүүлэх үүднээс зарим байгууллагуудыг өөрсдөө IT боловсон хүчинтэй байхыг шаардаж байгаа. Үүнтэй холбогдоод IT мэргэжилтэн бэлтгэх тал дээр бусад боловсролын салбарууд, их дээд сургуулиудтайгаа хэрхэн хамтарч ажиллаж байна вэ. Энэ жил жишээлбэл хэдэн оюутан залуус яг энэ IT технологийн салбар дээр нэмж бэлтгэж байгаа. Цаашид энэ оюутнуудын тоог ер нь хэрхэн бэхжүүлэх тал дээр тоо авъя. Баярлалаа.

Ж.Золжаргал: Асуултад хэн хариулах вэ. 5 дугаар микрофон нээж өгнө үү.

Л.Сонор: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор. Яг одоогийн байдлаар Хүнсний хувьсгал буюу Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан энэхүү хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 1,3 их наяд төгрөгийн зээлийг бол олгоод байгаа. 2023 онд 832 тэрбум төгрөг, 2024 онд 509 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд энэ оны Их Хурлын 63 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөр, хөдөлгөөний хүрээнд бол малын гаралтай түүхий эдийн инновац шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Энэ хүрээнд бол ноос ноолуур, арьс ширний үйлдвэрлэл эрхлэгчид зориулаад 2024 онд бол нийтдээ 228 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 45 аж ахуйн нэгжид олгосон бол 2025 онд 410 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг банкнуудын эх үүсвэрээр олгож, зээлийн хүүгийн дэмжлэгт нийтдээ 70 тэрбум төгрөгийг Засгийн газар хариуцан төлөхөөр татаас бол олгосон байгаа. Шинэ хоршоо чинээлэг малчин Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд бол мөн энэ онд батлагдсан. Шинэ хоршоо чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж заасны дагуу 2024 онд 1 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг банкнуудын эх үүсвэрээр олгохоор санхүүжилтийн гэрээг бол байгуулсан. Үүнээс бол 610 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг бол олгоод байгаа. 2025 онд нэмж шинээр 500 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, зээлийн хүүгийн дэмжлэгт 105,3 тэрбумын татаасыг Засгийн газраас хариуцан төлөхөөр тусгагдсан байна.

Ж.Золжаргал: Тодруулах уу. Пунсалмаа гишүүний микрофоныг нээж өгнө үү. Хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг ойлголоо. Энэ хөнгөлөлттэй зээлээр санхүүжиж байгаа дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжүүдийг И-цахим худалдан авалтаар импорт тарифын бодлогоор яаж дэмжиж байгаа вэ. Энэ зөвхөн зээл авахаасаа гадна цаашдаа бас уялдаа холбоотой төрийн дэмжлэгүүд хэрэгтэй байна. Энэ манай энэ IT технологийн энэ салбар дээр яаж дэмжиж байгаа вэ.

Ж.Золжаргал: Нэмэлт хариулт байна уу. 4 номер.

Ц.Баатархүү: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Маш тодорхой асуулт асуугаад байна гэж бид нар үзэж байна. Нэг тодорхой баяртай мэдээг дуулгамаар байна. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль батлагдсантай холбогдуулаад мэдээллийн технологийн компаниудыг дэмжих виртуал бүс гэдгийг байгуулж байгаа. Виртуал бүс гэдэг нь бол заавал одоо Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг байх нь хамаагүй. Монгол Улсын хаана ч үйл ажиллагаа явуулдаг байж болно. Инновац, мэдээллийн технологийн чиглэлээр ажилладаг бол татварын болон татварын бус дэмжлэг буюу 8 төрлийн дэмжлэг үзүүлнэ.

1 дүгээрт нь бол дотоодын болон гадаадын холбогдох байгууллагад патент авах зардал дээр грант олгох гэж байгаа. Экспортод чиглэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүнд нь олон улсын стандартыг баталгаажуулах юм бол тодорхой хэмжээний бас урамшуулал олгоно. НДШ-ийн төлөлтөд нь нөхөн олговор олгоно. .../минут дуусав/

Ж.Золжаргал: Баатархүү сайдын микрофон нэмж өгье.

Ц.Баатархүү: Хиймэл оюун ухааны төсөлд өөрийн зардлаа одоо 60 хувийг нь гаргасан бол 40 хувь дээр нь дэмжлэг үзүүлнэ. Дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох энэ олон ажлууд дээр 8 төрлийн ийм дэмжлэг

үзүүлэх журмын төслийг боловсруулаад, одоо Сангийн яам, Татварын ерөнхий газар, нийгмийн даатгалтай ойлголцох энэ ажлын хэсэг явж байгаа. Нэгэнт 2025 оны төсвийн жил эхэлсэн учраас мэдээллийн технологийн компаниуд Баян-Өлгийд байна уу, Хэнтийд байна уу виртуал бүсэд бүртгүүлээд шалгуур хангах юм бол хаанаас ч хамаагүй холбогдоод дэмжлэг авах энэ боломж бол нээгдэж байгаа. Энэ бол 2026 оноос эхэлнэ гэдгийг хэлье. Мэдээллийн технологийн чиглэлээр ямаршуу оюутнууд байна вэ гэхээр Монгол Улсад 1500 орчим оюутан бэлтгэгдэн гарч байна. Гүүгл компанитай өнгөрсөн жилээс хамтраад бид нар 1 мянга орчим оюутныг сургаж байна. Гүүглтэй хамт хөгжье гэдэг байдлаар. Нэмээд Япон улсад бусад өндөр хөгжилтэй улсуудад яг ийм шаардлагатай .../минут дуусав/

Ж.Золжаргал: Дахиад 1 минут нэмж өгье. 4 дүгээр микрофон.

Ц.Баатархүү: Тэгээд мэргэшүүлэх чиглэлээр бид нар цахим элч гэж нэрлээд байгаа мэргэшүүлэх чиглэлээр 1500 орчим хүнийг бэлдэж байгаа юм. Ер нь бол энэ кибер аюулгүй байдлыг бүгдийг нь бүхий л хувийн хэвшлийг төрийн байгууллага өөрөө хамгаалж хангана гэвэл хүч хүрэхгүй юм байна лээ. Тэгэхээр мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх эрх бүхий хувийн хэвшлүүдийг гаргасан. Ийм одоо 33, 34 байгууллага Монгол Улсад байна. Тэгэхээр жилдээ 1-4 удаа онц ноцтой, эмзэг ийм мэдээлэл хариуцаж байгаа, хариуцдаг хувийн хэвшлийн байгууллагууд аудит хийлгэх энэ боломж бололцоог бол бодлогын хувьд бид нар гаргаж өгсөн. Төрийн байгууллагуудыг бол энэ ТЕГ-ын дэргэд байдаг Кибер аюулгүй байдлын үндэсний төв, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хамтарч эрсдэлээс нь урьдчилан сэргийлье. Бүх хувийн хэвшил дээр хувийн хэвшил нь хувийн хэвшлээ хамгаалдаг ийм тогтолцоо руу шилжиж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье.

Мөн хамгийн зах зээл дээр эрэлттэй байгаа оюутнуудаар нэмж олон улсын өндөр хөгжилтэй улс орнуудын ийм сургуульд сурга .../минут дуусав/

Ж.Золжаргал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Ундром гишүүн зарчмын зөрөөтэй санал гаргаж байгаа. Тэгэхээр зарчмын зөрөөтэй санал дээр санал хураана. Тэгээд санал хураахаас өмнө зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя. Тэгээд энэ дээр холбоотой тайлбар асуулт, хариултыг явуулъя.

2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

“Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын урсгал зардлын ангилалд байгаа Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 1,5 тэрбум төгрөгийн төсвийг боловсролын салбарын багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд шилжүүлэх.” гэсэн ийм саналыг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундром гаргасан байна. Зарчмын зөрүүтэй саналтай холбоотойгоор асуулт асуух гишүүд мөн ажлын хэсгээс тайлбар. Ундром гишүүн саналаа тайлбарлана.

Ч.Ундром: Энэ Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бол Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.1 дүгээр зүйлд юу юунд зарцуулах вэ гэдгийг нь заасан байдаг юм байна. Тэгээд түрүүн бас Баатархүү сайд надад дутуу хариулт өгсөн байна. Юунд зарцуулж болох вэ гэхээр өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг ард иргэдэд

алслагдсан сүлжээ хүрээгүй газарт хүртээмжтэй хүргэх 1-д, 2-т үйлдвэрлэхэд өртөг өндөр үндэсний түүх, соёл уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн хүргэх гэдэг нь бол таны өгсөн тайлбар, 3-д нь өргөн нэвтрүүлгийн радио телевизийн бүтээл үйлдвэрлэлийг дэмжих буюу бас зүгээр май гээд өгч болох нь байна. Тэгэхээр өнөөдөр яг энэ бол манай улсад тулгарч байгаа 1 дүгээр номерын эрэмбийн асуудал биш. Сая энэ төсвийн тодотголыг Засгийн газар оруулж ирэхдээ цэцэрлэгийн багш нарын гүйцэтгэлийн санхүүжилтийг хассан байна. Яг 1,5 тэрбумаар хассан байна. Тэгэхээр бид нар арайхийж нөгөө сугалааны хүүхэд цэцэрлэгт ордог тэр тогтолцооноос гарчхаад одоо тэгээд багш нарыг нь цалингүй болгож болохгүй байна. Тийм учраас энэ сангийн үйл ажиллагааг тодорхой хэмжээгээр дорвитойхон танаад, энэ мөнгөө цэцэрлэгийн багш нарын гүйцэтгэлийн үнэлгээнд оруулах нь өнөөдөр манай улс орны тулгамдсан асуудал юм байна гэж бодоод энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргасан. Тийм учраас эрхэм гишүүдээсээ энэ саналыг дэмжиж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Өөр хамгаалж үг хэлэх хүн сонсох билүү. Ундрэм гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаар санал хураая. Томьёоллыг би дахиад уншаад өгье.

“Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын урсгал зардлын ангилалд байгаа Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 1,5 тэрбум төгрөгийн төсвийг боловсролын салбарын багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд шилжүүлэх.” гэсэн санал байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ундрэм. Түрүүн тайлбар сонсчихсон болохоор дэг байхгүй юм байна. Саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явна. Санал хураалт. Энэ чинь яах билээ 50/50 болчихоор санал хураалт дахиад явуулж болно шүү дээ. Горимын санал гаргах хүн байна уу. Би горимын санал гаргая. Төхөөрөмж дээр ажилласангүй. 50, 50 хувиар санал тэнцчихлээ. Санал дахин хураалт. Санал хураалтыг хүчингүй болгоё. Төхөөрөмж ажиллаагүй тул түрүүчийн санал хураалтыг хүчингүй болгох горимын санал дахиад санал хураалт явуулъя даа. Сая би дүн гарахаас нь өмнө хүчингүй болгоё гээд зарлачихсан болохоор хаагдчихсан байх. Төхөөрөмж ажиллаагүй тул санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураая. Санал хураалтыг хүчингүй болгоё. Төхөөрөмж ажилласангүй. Миний төхөөрөмж бол ингэдэггүй юм. Өнөөдөр л ингээд байх юм. Ямар учиртай юм. Төхөөрөмж ажиллаагүй тул санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг дахин явуулъя. Горимын санал байгаа юм уу. Пунсалмаа гишүүний микрофон нээж өгнө үү.

Б.Пунсалмаа: Төхөөрөмж ажилласангүй. Горимын санал гаргаад, дэмжсэнээ илэрхийлье.

Ж.Золжаргал: Санал хураалтыг хүчингүй болгоё. Пунсалмаа гишүүний горимын саналын дагуу төхөөрөмж ажиллаагүй учраас санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. Санал хураалт хүчингүй боллоо. Ингээд Ундрэм гишүүний гаргасан томьёоллын дагуу бүгдээрээ алдаагүй байна шүү. “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын урсгал зардлын ангилалд байгаа Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 1,5 тэрбум төгрөгийн төсвийг боловсролын салбарын багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээ рүү шилжүүлэх.” санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ундрэм. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал

хураана. Санал хураалтад оролцсон гишүүдийн 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

14.56 цаг.

Дараагийн асуудал байгаа. 2 дугаар асуудал нь болохоор тогтоолтой холбоотой.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эхлүүлье ээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга уу. Асуулттай гишүүд байхгүй байна.

Дараа нь 2 дугаар зүйл нь. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү. Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулттай гишүүд байвал нэрээ өгнө үү. Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Одоо ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн барьсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулттай гишүүд байна уу. Асуулттай гишүүд байхгүй байна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд хэлэлцэж дууслаа.

Дараагийнх нь 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн барьсан **“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хэлэлцэнэ.**

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулттай гишүүд байна уу. Асуулттай гишүүн байхгүй байна. Ингээд санал хураалт байхгүй.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн барьсан “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны шийдвэрийг танилцуулах тухай Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөсний мэдэгдье.

15.04 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ